



УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн ИТХ-ын захиалга, аймгийн Аудитын газрын 2016 онд бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан.



Хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрийг дэмжих зээлийн ашиглалт, зарцуулалт хэвийн явагдаж байна.

Хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 2014, 2015 онд олгосон зээлийн ашиглалт, зарцуулалтын үр дүн

Товчилсон үгийн тайлал:

ХЭДС – Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

СХС – Сум хөгжүүлэх сан

ЖДҮДС – Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан

ИТХ – Иргэдийн төлөөлөгчдийн хурал

ТХШС – Төрийн хяналт шалгалтын стандарт

АДБОУС – Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аймгийн ИТХ-ын захиалга, Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 2014, 2015 онуудад олгосон зээлийн ашиглалт, зарцуулалтын үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитыг дараах зорилтын хүрээнд хийж гүйцэтгэв. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх.
- Зээлдэгч хуулиар болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэх.
- Хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, сум хөгжүүлэх сангийн асуудал хариуцсан төрийн байгууллага хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэх

Хамарсан хүрээ

Аудитаар 2014-2015 онуудад хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан 2015 онд сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн үр дүн, хэрэгжилт, холбогдох эрх бүхий байгууллагууд, зээлдэгчийг хамрууллаа.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд ТХШС, гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-ийг ашиглах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, зээлийн үйл ажиллагааг газар дээр үзэж танилцах, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.

Нийцлийн аудитыг аймгийн Аудитын газрын ахлах аудитор С.Алтанхундага, ахлах шинжээч М.Батсуурь, аудитор Т.Намжил, С.Батсайхан, шинжээч Л.Бат-Очир, Я.Зунгарав нар хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих үйл ажиллагаанд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2011 оны 375 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”, 2 дугаар хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох журам”-ыг мөрдөж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эх үүсвэрээс хөнгөлөлттэй нөхцөлтэйгөөр малчин болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнд 5 сая хүртэл төгрөг, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнд 10 сая хүртэл төгрөгийн зээлийг олгож байна. Уг зээлийг олгохдоо Хөдөлмөрийн хэлтсээс дэмжигдсэн төслийг арилжааны банк судалж шаардлага хангасан төслийг санхүүжүүлж байна. Увс аймгийн хувьд арилжааны банкууд 24 сарын хугацаагаар сарын 0.85 хувийн хүүтэйгээр олгож байсан ба 2015 онд Хөдөлмөрийн яам, Төрийн банкттай байгуулсан гэрээнд сарын хүүг 0.75 хувь болгон өөрчилсөн байна. Зээлийн хугацааны хувьд 60 хүртлэх сараар тогтжээ.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих үйл ажиллагаанд Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль, Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/44 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ыг мөрдөж байсныг Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 100, 2016 оны 48 дугаар тушаалаар шинэчилсэн байна.

Түүнчлэн Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавихтай холбоотой харилцааг Монгол улсын Засгийн газрын 2011 оны 134 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-аар зохицуулж байсныг Монгол улсын Засгийн газрын 2016 оны 153 тоот тогтоолоор шинэчлэн баталсан байна.

Зээлийн нөхцөл нь 36 сар хүртэл хугацаагаар жилийн 3 хүртэл хувийн хүүтэй олгогдож байсан бол шинэчлэн баталсан журмаар жилийн 3 хувийн хүүтэй олгохоор тогтоосон байна.

Сангийн хөрөнгийг жижиг дунд үйлдвэр эрхлэгчид шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгож, тэднийг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, өргөтгөх, шинэчлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

Бүлэг1: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж байна

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу олгосон байна.

Хөдөлмөрийн яамнаас 2014 онд аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жижиг зээлийн эх үүсвэрт 500.0 сая төгрөг хуваарилагджээ. Улаангом суманд иргэдээс ирүүлсэн 908.1 сая төгрөгийн санхүүжилт хүссэн 206 төсөл хүлээн авчээ. Уг эх үүсвэрийг сумын суурин хүн амын тоонд харьцуулан санхүүжилтийг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн, Төрийн банкт хамтарсан ажлын хэсэг байгуулан төсөлд ажлын байрны зураг авалт хийж сонгон шалгаруулалтыг зохион байгуулжээ. Нийт төслөөс аймгийн төвийн 96 төсөл, бусад сумдад 111 төсөл, нийт 207 төсөл шалгаруулж 594.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.


2015 онд Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн жижиг зээлийн эх үүсвэрт 120.0 сая төгрөгийн санхүүжилт хуваарилагджээ. Аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн даргын тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. ХЭДС-ийн жижиг зээлийн талаарх мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон хэлтсийн вэйб сайтаар зар мэдээллийг иргэдэд хүргэжээ. 2015 онд 342.0 сая төгрөгийн санхүүжилт хүссэн 68 төсөл хүлээн авч ажлын хэсэг төслийн ажлын байранд зураг авалт хийж 40 төсөлд 119.0 сая төгрөгийн санхүүжилтийг Төрийн банкаар дамжуулан олгосон байна.

Аймгийн ХЭДС-аас 2014-2015 онд олгогдсон зээл

№	Олгосон он	Зээлийн хэмжээ /сая төг/	Төсөл хэрэгжүүлэгчийн тоо
2	2014	594.2	207
3	2015	119.0	40
Нийт дүн		713.2	247

2014, 2015 онд дэмжигдсэн нийт 247 төслөөс 136 төсөл нь аймгийн төвд ,111 төсөл нь суманд хэрэгжүүлсэн байна.

2014, 2015 онд дэмжигдсэн төслийн судалгаа



Дэмжигдсэн төслүүдийн зээлдэгчийн байдал:

№	Олгосон он	Малчин	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Нөхөрлөл хоршоо байгуулах иргэн
2	2014	1	37	2
3	2015	47	158	2
Нийт дүн				

/Давхардсан тоогоор/

№	Олгосон он	Гэр хорооллын иргэд	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	Бизнес инкубаторт хамрагдсан	45-аас дээш насны
2	2014	35	0	2	5
3	2015	72	14	70	53
Нийт дүн					

Дэмжигдсэн төслийг салбараар ангилбал

Д/д	Олгосон онууд / салбараар/	Төсөл хэрэгжүүлэгч тоо	
		2014 он /сая төг/	2015 он / сая төг /
1	Газар тариалан	56	3
2	Хатуу оёдол	28	10
3	Зөөлөн оёдол	18	
4	Үйлдвэрлэлийн чиглэл	20	7
5	Үйлчилгээний чиглэл	15	
6	Мал аж ахуй өсгөж үржүүлэх	21	
7	Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах	9	
8	Гагнуур, засвар	4	9
9	Авто засвар	8	
10	Дуу бичлэг	1	
11	Гар урлал	2	
12	Модон эдлэл үйлдвэрлэл	22	9
13	Үсчин	3	2
Нийт дүн		207	40

1.2. Зээл авсан иргэн, аж ахуйн нэгж зээлийг зориулалтын дагуу ашиглаж, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна.

2014, 2015 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эх үүсвэрээс дэмжигдсэн төслийн үйл ажиллагаатай аудитын явцад түүвэр байдлаар томоохон төслүүдийг сонгон танилцахад зээлийг зориулалтын дагуу ашиглаж, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна.

1.3. Гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнд 2015, 2016 онд хяналт хийгээгүй байна.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс 2014 оны 9 сард Улаангом сум болон Баруунтуруун, Өндөрхангай, Зүүнхангай, Цагаанхайрхан, Хяргас сумдад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2014 онд олгосон хөнгөлөлттэй зээлийн хэрэгжилтэд хяналт хийж зөрчил арилгуулах зөвлөмж чиглэл өгчээ.

2015, 2016 онуудад Хөдөлмөр эрхлэлтийн сангаас олгосон зээлийн үйл ажиллагаанд Хөдөлмөрийн хэлтсээс хэрэгжилтийн явц, гэрээний биелэлтэнд хяналт хийгээгүй байна.

Тухайн зээл арилжааны банкаар дамжин олгогдож зээлийн эргэн төлөлтийн эрсдлийг арилжааны банк хүлээж байгаа тул зээл, зээлийн хүүний эргэн төлөлтөнд хугацаа хэтрэлт гаргаагүй байна.

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалт хэвийн явагдаж байна.

Бүлэг 2: Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зээлийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж байна

2.1. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зээлийг хууль тогтоомжийн дагуу олгосон байна

2014 онд Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/44 тоот тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ыг үндэслэн аймгийн ИТХ-ын 2014 оны А/92 дугаар тогтоолоор төсөл сонгон шалгаруулах дэд комиссыг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Төсөл сонгон шалгаруулах дэд комисс 3643.0 сая төгрөгийн 73 төсөл хүлээн авч журмын дагуу үнэлж 20 төслийг шалгаруулжээ. Арилжааны банкнаас 18 төсөлд 710.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

2015 онд аймагт төсөл сонгон шалгаруулах дэд хороог Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 79 дүгээр тушаалыг үндэслэн Төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ.

Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 100 дугаар тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын хүрээнд 3926.0 сая төгрөгийн 67 төсөл хүлээн авч дэд хороогоор 500.0 сая төгрөгийн 20 төслийг дэмжсэн байна. Арилжааны банкнаас 18 төсөлд 480.0 сая төгрөг олгосон байна.

Аймгийн ЖДҮ-ийг дэмжих сангаас 2014-2015 онд олгогдсон зээл


№	Олгосон он	Зээлийн хэмжээ /сая төг/	Төсөл хэрэгжүүлэгчийн тоо
2	2014	710,5	18
3	2015	480,0	19
Нийт дүн		1190,5	37

Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/44 дугаар тушаалаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын 5.1-д “Комисс, дэд

комиссын шийдвэрээр хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт хүссэн төслүүдийг хүлээн авах хугацааг тохирч хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх үүргийг Хөдөлмөрийн яам, сан, нийслэл, аймаг, дүүргийн хөдөлмөрийн газар хэлтэс хариуцна” гэж заажээ.

Үүний дагуу аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс жижиг дунд үйлдвэр дэмжих сангаас олгох хөнгөлөлттэй зээлийн мэдээллийг аймгийн төвийн орон нутгийн телевизээр нийтэд мэдээллэж ажиллажээ.

2014, 2015 онуудад дэмжигдсэн 37 төслөөс аймгийн төвд 32, сумдад 5 төсөл хэрэгжсэн нь суманд ХЭДС-аас олгох зээлийн мэдээлэл хүрэх байдал дутагдалтай байгааг харуулж байна. Иймд аймгийн хэмжээнд зээлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр иргэдийг бүрэн хангаж ажиллахыг зөвлөмж болголоо.



Дэмжигдсэн төслийг салбараар ангилбал:

Д/д	Олгосон онууд / салбараар/	Төсөл хэрэгжүүлэгч тоо	2014 он /сая төг/	2015 он / сая төг /
1	Хүнсний үйлдвэр	3	115,0	
2	Мал аж ахуй	11	84,5	200,0
3	Барилга	6	280,0	30,0
4	Хөнгөн үйлдвэр	5	70,0	40,0
5	Ахуй үйлчилгээ	6		65,0
6	Үйлчилгээ	2	51,0	90,0
7	Газар тариалан	4	110,0	55,0
	Нийт дүн	37	710,5	480,0

2.2. Зээлдэгчид зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2014, 2015 онд дэмжих сангаас дэмжигдсэн 37 төслөөс аудитын явцад 28 үйл ажиллагаатай танилцан хэрэгжилтийг үзэж ажлын байрны зураг авалт хийлээ.

Аймгийн ЖДҮ-ийг дэмжих сангаас хөнгөлөлттэй зээл авснаар хөөсөнцөр сэндвич хавтангийн үйлдвэр, хөнгөн блокны үйлдвэр, бетон зуурмагийн үйлдвэр, барилгын материалын үйлдвэр, 00-ын цаасны үйлдвэр, эсгийний үйлдвэр, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, зөөлөн оёдлын үйлдвэр, гутлын үйлдвэр, мебель тавилгын үйлдвэр, фермерийн аж ахуй, жимс боловсруулах үйлдвэр, давсны үйлдвэр, жимс хадгалах хөргөлтийн зоорь, талх нарийн боовны үйлдвэр, төмөр эдлэлийн үйлдвэр зэрэг томоохон үйлдвэрүүд бий болж, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна.

Үүнээс үзэхэд дэмжих сангаас олгосон зээлийн ашиглалт, зарцуулалт зориулалтын дагуу ашиглагдаж байна.

2.3. Эргэн төлөгдөх зээл, хүүгийн орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлж байна

Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/44 дугаар тушаалаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын 1.3-д “Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгохдоо төслийг сонгон шалгаруулах комисс, дэд комиссын шийдвэрийг үндэслэн гэрээ байгуулсан арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан олгоно” гэж заасны дагуу аймагт үйл ажиллагаа явуулж байгаа ХААН, Хас банкаар дамжуулан 2014, 2015 оны жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлийг олгосон байна.

Аудитын явцад хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийн мэдээллийг арилжааны банкнаас 2016 оны 5 сарын 31-ны байдлаар гаргуулахад хугацаа хэтэрсэн зээлдэгч байхгүй байна.

2.4. Зээлийн гэрээ байгуулж, гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт хийсэн байна.

Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/44 дугаар тушаалаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын 7.1-д Хяналт, шинжилгээ үнэлгээг жилд 2-оос доошгүй хийж, тайланг тухай бүр танилцуулан үр дүнг тооцон ажиллана” гэж заажээ.

Энэ хүрээнд аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс 2014, 2015 онд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас хөнгөлөлттэй олгосон зээлийн үйл ажиллагаанд дараахь байдлаар хяналт хийсэн байна. Үүнд:

- 2014 оны 9 сард Улаангом, Баруунтуруун, Өндөрхангай, Зүүнхангай, Цагаанхайрхан, Хяргас сумдын 2009-2011 онуудад олгосон зээлийн хэрэгжилтэнд
- 2015 оны 3 сард Аж үйлдвэрийн яамнаас томилогдсон ажлын хэсэгтэй хамтран 2013, 2014 онд аймгийн ЖДҮ-ийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хамруулан

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 2015 онд зээл олгохоор дэмжсэн төслийн санхүүжилтийг оны сүүлээр олгосноос төслийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Аймгийн төвөөс бусад сумдад дэмжих сангийн эх үүсвэрээр олгогдож байгаа зээлийн мэдээлэл хүргэх байдал хангалтгүй байна.
2. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна
3. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлийн хэрэгжилтэнд тавих хяналтыг жилд нэг удаа хийсэн байна.

Зөвлөмж: Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга, Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэнд зөвлөж байна.Үүнд:

1. Зээлийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг аймаг, сумдын иргэн, аж ахуйн нэгжид жигд хүргэх.
2. Хөдөлмөрийн сайдын 2013 онд баталсан журмын дагуу жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлийн хэрэгжилтэнд тавих хяналтыг тухай бүр хийж байх.

Бүлэг 3: Сум хөгжүүлэх сангийн зээлийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан байна

3.1. Сум хөгжүүлэх сангийн зээлийг хууль тогтоомжийн дагуу шалгаруулсан ч зарим зээлдэгчийн зээлийг хэдэн сар дамжуулан хэсэгчлэн олгосон байна.

Засгийн газрын 2011 оны 134 тоот тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.3-д “Төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг сумын ИТХ-ын тогтоолоор 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулна. Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийг сумын Засаг дарга ахлах бөгөөд зөвлөлийн 3 гишүүн нь тухайн сумын иргэний төлөөлөл байна” гэж заажээ. Үүний дагуу аймгийн 19 суманд төсөл шалгаруулах зөвлөл байгуулагдсан ба зөвлөл нь сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс санхүүжихээр иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн төслийг сонгон шалгаруулж байна.

Мөн Улаангом сумын сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хэрэгжилтийн үр дүнд хяналт, үнэлгээ хийх үүрэг бүхий хяналтын комиссын дарга Ү.Уламбаяр жимс, жимсгэнэ боловсруулахад зориулан 10.0 сая төгрөгийн зээл авсан байгаа нь ашиг сонирхолын зөрчил үүсэх, хяналт шалгалтын бодит үнэлгээнд нөлөөлөх эрсдэл үүсгэж байна.

Улаангом сум Засгийн газрын 2011 оны 134 тоот тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 4.4-д “Зөвлөл нь иргэн, аж ахуйн нэгжийн ирүүлсэн төслийг энэхүү журмын 4.1, 4.2-т заасан шалгуур, шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянан үзэж, зөвлөлийн хурлаараа хэлэлцэн шийдвэрлэнэ. Зөвлөлийн шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор Засаг дарга зээл олгох захирамж гаргана”, 4.6-д “Зээлийн гэрээг байгуулснаас хойш ажлын 7 хоногийн дотор зээлийн хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгжийн дансанд шилжүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна. Тухайлбал:

Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс зээлийн санхүүжилтийг олгохдоо Улаангом сум зарим зээлдэгчид 2-6 сараар, он дамжуулан олгосон байна.

Д/д	Зээлдэгчийн нэр	Санхүүжилт олгосон он сар	Санхүүжилтийг олгосон тоо
1	Б.Одонтуяа	2014.12-2015.02	5
2	Ц.Данзанпүрэв	2014.12-2015.02	5
3	Д.Нармандах	2014.12-2015.02	3
4	Ж.Очирдарь	2015.01-2015.02	2
5	Х.Түмэнбаяр	2015.01-2015.06	6

6	Н.Ганхуяг	2015.03-2015.04	5
7	Д.Пүрэвсүрэн	2015.03-2015.05	5
8	Э.Амарсайхан	2015.08-2015.09	3
9	Л.Байгалмаа	2015.11-2015.12	3
10	Б.Жавзан	2015.12-2016.03	4
11	Д.Энхбаатар	2015.12-2016.03	4
12	О.Ганболд	2015.12-2016.03	3

Зээлийн санхүүжилтийг олон сар дамжуулан хэсэгчлэн олгож байгаа нь төслийн үр дүн буурах, зээлийг зориулалт бусаар зарцуулах, эргэн төлөлтийн хугацаа хэтрэх зэрэг эрсдэл үүсэж байна.

Өлгий сум иргэн С.Ойдовын төслийг дэмжиж Сум хөгжүүлэх сангаас 50.0 сая төгрөг олгохоор 2015 оны 6 сарын 30-ны өдрийн 54 тоот гэрээ байгуулсан боловч 25.0 сая төгрөгийн санхүүжилт өгсөн байна. Иймд дээрх журмын дагуу гэрээний нөхцлийг өөрчлөн нэмэлт гэрээ байгуулж ажиллах нь зүйтэй.

3.2. Зээлдэгч сум хөгжүүлэх сангийн зээлийг зориулалтын дагуу зарцуулж байна

Засгийн газрын 2011 оны 134 тоот тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 1.8-д “Сангаас олгох зээлийн хүүгийн орлогын 50 хүртэл хувийг сумын **ИТХ-ийн шийдвэрээр** байгуулагдсан төсөл сонгон шалгаруулах, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих ажлыг зохион байгуулах зөвлөлийн **үйл ажиллагаанд** зарцуулж болно. Үлдэх хувийг сангаас олгох зээлийн эргэлтийн хөрөнгө болгож ашиглана” гэж заажээ.

Гэтэл Улаангом сум ИТХ-ын шийдвэргүйгээр Сум хөгжүүлэх сангийн хяналтын комисст хяналт хийсний урамшуулалд өдрийн 30.0 мянга төгрөгөөр тооцож нийт 1050.0 мянга, хоолонд 289.1 мянга, бензин 92.9 мянган төгрөг, нийт 1432.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Хяналт шалгалтаар явсан шатахуун зарцуулалтын замын хуудсыг хөтлөхдөө явсан чиглэлийг нэг бүрчлэн хөтлөхгүйгээр Улаангом хот дотор гэх мэтээр нэгтгэн хөтөлсөн нь шатахуун зарцуулалтын тооцоог хэрхэн хийсэн нь тодорхойгүй байна.

Мөн хоолонд орсон зарим баримт нь гарын үсэг, тамга тэмдэггүй зэрэг зөрчил байна. Цаашид сангийн хөрөнгийг журмын дагуу анхан шатны хүчин төгөлдөр баримтаар зарцуулж байхыг зөвлөмж болгов.

Засгийн газрын 2011 оны 134 тоот тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 1.5-д “Сангийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгоход зориулагдана”, 1.9-д “Сангийн хөрөнгийг сумын төсвийн алдагдал нөхөх, төсөвт байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэх, байгалийн гамшигаас учирсан хохирлыг нөхөн төлөх зэргээр энэхүү журмын 1.5-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэж заасан байна.

Түргэн сум Сум хөгжүүлэх сангаас 2015 оны 2 дугаар сард Ш.Нина гэсэн нэрээр 3500.0 мянган төгрөгийг гарган сумын ойн бэлтгэл үйл ажиллагаанд зарцуулсан гэх бөгөөд 2015 оны 7 сарыг хүртэл 3240.8 мянган төгрөгийг эргүүлэн төлж 2016 оны 4 сарын 1-ний байдлаар үлдэгдэл 259.2 мянган төгрөгийг төлөөгүй байсанд төлбөрийн акт тогтоолоо.

Мөн 2015 оны 2 дугаар сард өвсний үнэ нэрээр 2479.7 мянган төгрөгийг тушаал шийдвэргүйгээр сумын ЗДТГ-ын ажилтнуудад шагнал, урамшуулал хэлбэрээр өгсөн байсныг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Засгийн газрын 2011 оны 134 тоот тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.2.3-т “сумын Засаг дарга төсөл нь шалгарсан иргэн, аж ахуйн нэгжтэй зээлийн гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг хангуулах, хэрэгжилтийн явц, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах үүрэгтэй” гэж заажээ.

Аудитын явцад Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 2015 онд зээл авсан зарим зээлдэгчийн төслийн хэрэгжилт хангалтгүй /төсөлд дурьдсан ажлын байр, тоног төхөөрөмжөө бүрэн бэлтгээгүй, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж эхлээгүй/ байсанд зээлийг зориулалтын дагуу зарцуулах, үйл ажиллагааг хэвийн явуулахыг албан шаардлага болгов. Тухайлбал:

- Улаангом сумын иргэн И.Чойнид “Цацаргана тариалах” 15.0 сая, Н.Эрдэнэсүрэн “Халуун ус” 6.0 сая, Н.Ганхуяг “Ажлын бээлий” 15.0 сая Л.Оюунчимэг “Аялал жуулчлалын үйлчилгээ” 10.0 сая, Д.Энхбаатар “Хатуу оёдол” 10.0 сая, нийт 56.0 сая
- Завхан сумын иргэн Д.Одонбаяр “Загас, загасан бүтээгдэхүүн боловсруулах төсөл” 19.0 сая
- Тэс сумын иргэн Д.Дээшин “Цацаргана тариалах” 5.0 сая, иргэн Ж.Батжаргал “Гэрийн тавилга үйлдвэрлэх” 5.0, нийт 10.0 сая
- Түргэн сумын иргэн Ж.Ууганзаяа “Эсгий үйлдвэрлэл эрхлэх” 24.0 сая
- Зүүнхангай сумын иргэн Ц.Лхагвасүрэн “Эсгийний үйлдвэрлэл эрхлэх” 12.0 сая

Мөн Улаангом сумын иргэн Э.Амарсайхан “Модон эдлэл” чиглэлээр төсөл 10.0 сая төгрөгийн зээл авсан боловч газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

3.3. Эргэн төлөгдөх зээл, хүүгийн орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлээгүй байна

Аймгийн хэмжээнд 19 сумын нийт 266 зээлдэгчийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн үндсэн зээлийн төлбөр 736.4 сая, гэрээний дагуу тооцогдох хүү 19.7 сая, алданги 81.9 сая, нийт 838.7 сая төгрөгийн акт тогтоолоо. Хүснэгтээр харуулав.

№	Сумын нэр	Зээлдэгчийн тоо	Хугацаа хэтэрсэн буюу зориулалт зарцуулсан зээл	Зээлийн хүү	Алданги буюу торгууль	Нийт дүн
1	Баруунтуруун	7	15,000,000	251,600	1,480,000	16,731,600
2	Бөхмөрөн	12	16,763,135	258,964	1,553,784	18,575,883
3	Давст	2	28,284,300	489,412	98,529	28,872,241
4	Завхан	3	23,907,725	153,009	1,434,463	25,495,197
5	Зүүнговь	15	76,087,152		2,144,208	78,231,360
6	Зүүнхангай	11	22,447,971		1,289,999	23,737,970
7	Малчин	8	37,253,250	1,633,031	1,633,031	40,519,313
8	Наранбулаг	12	35,731,796	592,234	1,184,468	37,508,498
9	Өлгий	14	39,122,540	244,800	8,126,852	47,494,192
10	Өмнөговь	18	33,452,505	1,925,273	4,374,510	39,752,288
11	Өндөрхангай	9	42,842,550	682,330	1,364,659	44,889,539
12	Сагил	17	60,130,840	1,118,230	247,712	61,496,782
13	Тариалан	26		2,999,392		2,999,392

14	Түргэн	14	30,606,515	844,415	891,374	32,342,304
15	Тэс	39	100,506,000	3,747,090	7,494,180	111,747,270
16	Ховд	9	30,970,434	1,985,092	2,726,000	35,681,526
17	Хяргас	10	35,490,556	552,486	1,104,972	37,148,014
18	Цагаанхайрхан	14	19,830,115	187,395	693,165	20,710,675
19	Улаангом	26	102,439,749	2,147,640	45,074,518	149,661,907
	Дүн	266	750,867,133.0	19,812,392.7	82,916,424.2	853,595,950.9

3.4. Зээлийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнд тавих хяналт зарим суманд сул байна.

Засгийн газрын 2011 оны 134 тоот тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.1.5-д “Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтанд хяналт тавих чиг үүрэг бүхий 7 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус ажлын хэсгийг сумын ИТХ-ын төлөөлөгчөөр ахлуулан байгуулна”, 5.3-д “Энэхүү журмын 3.1.5-д заасан ажлын хэсэг сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтэнд тухайн санхүүгийн жилд 2-оос доошгүй удаа шалгалт хийж, дүнг иргэдийн Төлөөлөгчдийн болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлж байна” гэж заажээ.

Улаангом сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан комисс сум хөгжүүлэх сангийн олголт, явц, хугацаа хэтэрч байгаа зээлийн эргэн төлөлт зэрэгт 2015 оны 2 дугаар сард 2013 онд зээл авсан 26 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан, 2015 оны 7 дугаар сард 2014, 2015 онд зээл авсан 31 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан хяналт хийсэн байна.

Хийсэн хяналт шалгалт нь нэгдсэн удирдамжгүй шалгалтын тайланг гараар ганц хуудас тайлбар маягаар бичсэн, шалгалтын дүнг Иргэдийн төлөөлөгчдийн болон тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлээгүй, сумын нийт иргэдэд мэдээлээгүй байна.

Улаангом сумаас бусад сумдын хувьд СХС-ийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтанд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсэг ажиллаж байна.

Мөн аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс 2015 оны 12 дугаар сард Улаангом сумын Сум хөгжүүлэх сангаас 2011-2015 онуудад олгосон зээлийн хэрэгжилтэд хяналт хийж 3 зээлдэгчийн үйл ажиллагааг эхлүүлэх, СХС-ийн хөрөнгөөс хяналт хийсэн ажлын хэсгийн урамшуулал, хоол зэргээр үр дүнгүй зардал гаргахыг зогсоох зөвлөмж бичиг хүргүүлсэн байна. Аудитын явцад ажлын байрны зураг авалт хийхэд Хөдөлмөрийн хэлтсийн өгсөн зөвлөмжийн дагуу “БЭМАО” ХХК-ни 00-ийн цаасны үйлдвэрээ өргөтгөж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

2015 онд Өмнөговь сум Сум хөгжүүлэх сангийн дансанд мал хамгаалах сангийн 6220.0 мянга, байгаль хамгаалах сангийн 1700.0 мянга, нийт 7920.0 мянга, Улаангом сумын Сум хөгжүүлэх сангийн дансанд малжуулах сангийн 20000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлэн зарцуулсан байна. Энэ нь сангийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах эрсдэл үүсгэж байна.

Засгийн газрын 2016 оны 153 тоот тогтоолоор батласан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.4-д “Энэ журмын 1.3-т заасан дансанд **сангийн хөрөнгөөс бусад хөрөнгө байршуулахыг хориглоно**” гэж заасныг мөрдөж ажиллахыг зөвлөмж болгов.

3.5. Өмнөх оны аудитаар өгсөн актыг 82.1 хувь, албан шаардлагыг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Засгийн газрын 2011 оны 132 тоот тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 5.2-т “Сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг сумын Засаг дарга хариуцна” гэж заажээ.

2015 онд Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар 636.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 194.0 сая төгрөгийн албан шаардлага тогтоосноос 608.7 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулсан байна. Мөн 79 иргэнтэй холбоотой 244.1 төлбөрийн актыг шүүхэд шилжүүлсэнээс 52 иргэний 164.1 сая төлүүлэхээр шийдвэр гаргуулж, 27 иргэний 80.0 сая төгрөгийн акт шүүхийн шатанд хянагдаж байна. Нийт актын биелэлт 82.1 хувьтай байна.

Өмнөх аудитын дүнг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж томоохон зөрчил гаргасан зарим сумдын Засаг дарга нарт хариуцлага тооцуулан, нийтлэг илэрсэн зөрчилтэй холбогдуулан 12 зөвлөмж хүргүүлсэн.

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Өмнөговь, Улаангом сумын сум хөгжүүлэх сангийн дансаар мал хамгаалах, байгаль хамгаалах сангийн хөрөнгө дамжин зарцуулагдсан байна.
2. Улаангом сум Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс хяналт хийсний урамшуулал, хоолны зардалд зориулалт бусаар зарцуулсан байна.
3. Улаангом сумын СХС-ийн зээлийн хэрэгжилтэнд хяналт шалгалтын дүнг Иргэдийн төлөөлөгчдийн болон тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлээгүй, сумын нийт иргэдэд мэдээлээгүй байна.

Зөвлөмж:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зарим сумын Засаг дарга нарт зөвлөж байна.Үүнд:

1. Засгийн газрын 2016 оны 153 тоот тогтоолоор батласан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.4-д “Энэ журмын 1.3-т заасан дансанд **сангийн хөрөнгөөс бусад хөрөнгө байршуулахыг хориглоно**” гэж заасныг мөрдөж ажиллах.
2. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг Засгийн газрын 2016 оны 153 тоот тогтоолын дагуу зориулалтаар нь зарцуулах.
3. Хяналт шалгалтыг нэгдсэн удирдамжийн дагуу явуулах дүнг Иргэдийн төлөөлөгчдийн болон тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлж байх.

Холбогдох байгууллагын санал



**УВС АЙМАГ
УЛААНГОМ СУМЫН
ЗАСАГ ДАРГА**
213400, Улаангом, Увс аймаг
Утас/Факс: 7045-3030

2016.07.05 № 690
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 2014, 2015 оны олгосон зээлийн зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй нэг бүрчлэн танилцлаа.

Танай байгууллагаас хийсэн гүйцэтгэлийн аудиттай санал нэгтэй байгаагаа мэдэгдэж байна.

ЗАСАГ ДАРГА  **О.ГАНХУЯГ**



**УВС АЙМГИЙН
ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТЭС**

213400, Увс аймаг, Улаангом, V баг

Утас: 70452020, 70455030, 70455040

E-mail: Uvs_khudulmur@yahoo.com

G-mail: Uvs_khudulmur@gmail.com

http://Uvs_khudulmur.gov.mn

2016-07-05 № 186

танай _____-ны № _____-т

УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 2014, 2015 онуудад олгосон зээлийн ашиглалт зарцуулалтанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй санал нийцэж байна.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗОРИГТБААТАР



12 371

D.2016 on alban foot.A5.07 sar

Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар

Хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 2014, 2015 онуудад олгосон зээлийн ашиглалт, зарцуулалтын үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн саналын хариу:

Холбогдох байгууллагаас гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй санал нэг байна гэсэн хариу ирүүлсэн тул тайлбар хийх шаардлагагүй болно.

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АХЛАХ ШИНЖЭЭЧ
АУДИТОР

ШИНЖЭЭЧ

С.АЛТАНХУНДАГА
М.БАТСУУРЬ
Т.НАМЖИЛ
С.БАТСАЙХАН
Л.БАТ-ОЧИР
Я.ЗУНГАРАВ